



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/89

Эг

Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дахь хэсгүүд, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар тугаал, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/31 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажилд сумын хэмжээний бүх үхэр, сарлагыг хамруулж 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн чанартай, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчлага өгч ажиллахыг "Баянбараат хайрхан" ХХК-ийн захирал (Т.Бямбадорж), "Шүтээн дэнж" ХХК-ийн захирал (Б.Мягмаржав) нарт үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулж, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд, малчдыг татан оролцуулж мэдээлэл хүргэн, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Ундрах)-д үүрэг болгосугай.

4. Уг ажилд хүн хүчээр хангаж, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Шажинбат)-д даалгасугай.

5. Дээрх аж ахуйн нэгжүүдэд олгох вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



ТАНСҮХ

232401177

Сумын Засаг даргын 2024 оны 06-р сарын 03-ны өдрийн 0185 тоот захирамжийн хавсралт



2024 ОНД ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	ААНэгжийн нэр	Малын тоо		Вакцин /тун/
		Үхэр	Нийт	
1	Баянбараат хайрхан ХХК	13500	13500	13.5
2	Шүтээн дэнж ХХК	10900	10900	10.9
		24400	24400	24.4

ХУВААРЬ ГАРГАСАН:

МАЛ ЭМНЭЛГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.УНДРАХ